



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 22

Есенбулаг сум

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "Н", 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангахыг орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагууд, Орон нутгийн өмчийн газар /З.Мөнхнасан/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2018 оны 11 сарын 14 өдрийн  
12 дугаар тогтоолын хавсралт

**ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНДСЭН  
ХӨРӨНГИЙГ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХУДАЛДАХ,  
ДАНСНААС ХАСАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ**

**Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Орон нутгийн өмчийн болон өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвийн байгууллагууд /цаашид орон нутгийн өмчит хуулийн этгээд гэх/-ын үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө /цаашид “эд хөрөнгө” гэх/-ийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах үйл ажиллагаа болон тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлт гүйцэтгэлийг тооцож, тайлагнахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал, эрхлэгч/ нь Орон нутгийн өмчийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид зааснаар эзэмших, ашиглах, үр өгөөжийг нь дээшлүүлэх, бүрэн бүтэн байдлыг хангах талаар тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд үүнийг “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний дагуу зохицуулна.

1.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бусад хуулийн этгээд байгууллага, иргэдэд ашиглуулах, түрээслүүлэхдээ Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан хууль тогтоомж болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “эрх бүхий байгууллага” гэх/-аас баталсан холбогдох журам, зааврыг мөрдөнө.

1.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа илүүдэлтэй ашиглалтгүй үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл элэгдлийн хэмжээ нь дуусаагүй боловч ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, актлах саналыг энэ журмын 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.5, 7.3.6-д заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэн аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

1.5. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс эд хөрөнгийг олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, данснаас хасах талаар ирүүлсэн саналыг хүлээн авч хянан үзээд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, шийдвэрийг тухайн байгууллагад хүргүүлнэ.

1.6. Орон нутгийн өмч эзэмшигч байгууллагад илүүдэлтэй ашиглалтгүй, эсхүл сэргээн засварлаж ашиглахад техник, эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тогтоогдсон эд хөрөнгийг зөвхөн дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэж, худалдах доод үнийг энэ журмын 6.2-т заасныг баримтлан тогтооно.

1.7. Эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагын худалдаанаас бусад нөхцлөөр худалдах, шилжүүлэх, актлах тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга /захирал, эрхлэгч/ хариуцан зохион байгуулж, биелэлтийг шийдвэрт заасан хугацаанд хэрэгжүүлсэн тухай холбогдох материалыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх үүрэг хүлээнэ. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавина.

## **Хоёр. ҮНДСЭН ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХ, АКТЛАХ САНАЛ ИРҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ**

2.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь энэ журмын 1.5-д заасан асуудлыг шийдвэрлүүлэхдээ дор дурдсан бичиг баримтаас тухайн харилцаанд хамааралтай баримт, материалыг бүрдүүлнэ.

- 2.1.1. Хуулийн этгээдийн эрх барих эсхүл харъяа дээд байгууллагын зөвшөөрөл;
- 2.1.2. Худалдан авах санхүүжилтын эх үүсвэрийг баталсан эрх бүхий байгууллагын шийдвэр, хуваарилагдсан төсөв;
- 2.1.3. Хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт;
- 2.1.4. Холбогдох мэргэжлийн байгууллагын акт, дүгнэлт;
- 2.1.5. Эдийн засгийн тооцоо, үндэслэл;
- 2.1.6. Худалдах, худалдан авах, зах зээлийн үнийн харьцуулсан судалгаа, худалдан авах дээд, худалдах доод үнийн санал;
- 2.1.7. Балансаас балансад шилжүүлэх бол өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл болон шилжүүлэн авах хуулийн этгээдийн хүсэлт;
- 2.1.8. Ашиглалтын хугацаа, элэгдлийн хэмжээ дуусаагүй, үлдэгдэл өртөгтэй боловч ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгийн эвдрэл, гэмтлийн шалтгааныг тогтоосон дүгнэлт, хохирлын хэмжээг мэргэжлийн эрх бүхий байгууллагуудаас тогтоосон акт, дүгнэлт, хууль хяналтын байгууллагын шийдвэр, буруутай этгээдийн хохирол барагдуулсныг нотлох баримт, сэргээн засварлаж ашиглахад шаардагдах эдийн засгийн тооцоо үндэслэл;
- 2.1.9. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй номыг устгах талаар гаргасан холбогдох мэргэжлийн байгууллагын зөвшөөрөл;
- 2.1.10. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй буу, галт зэвсгийн талаар Цагдаагийн байгууллагын албан бичиг, зөвшөөрөл;
- 2.1.11. Түүх соёлын дурсгалт зүйлсийн талаарх аливаа шийдвэрийг гаргахад соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын санал;
- 2.1.12. Тухайн хөрөнгийн өнгөт фото зураг;
- 2.1.13. Бусад шаардлагатай баримт материал;

2.2. Үл хөдлөх хөрөнгийн хувьд энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.

- 2.2.1. Үл хөдлөх хөрөнгийн байрлаж буй газрын эзэмших /ашиглах/ эрхийн гэрчилгээ, газар эзэмшүүлэх /ашиглуулах/ гэрээ, кадастрын зургийн хуулбар;
- 2.2.2. Үл хөдлөх хөрөнгөд хийсэн их болон урсгал засварын зардал, тухайн эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмнө хүлээсэн хариуцлагын /зээл, өрийн барьцаа, эрх бүхий байгууллагын шийдвэр/ талаарх мэдээлэл;
- 2.2.3. Барилгын хувийн хэргийн хуулбар, орчны тойм зураг, байгуулалтын зураг /план/, гадна, дотор талын өнгөт фото зураг, инженерийн шугам сүлжээний техникийн зургийн хуулбар, бусад баримт бичиг;

2.3. Тээврийн хэрэгслийн хувьд энэ журмын 2.1-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ:

- 2.3.1. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ, хувийн хэрэг, автотээврийн болон өөрөө

явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөгчийн гэрчилгээний хуулбар;

2.3.2. Техникийн үзүүлэлт, 3 талаас нь авсан өнгөт фото зураг;

2.3.3. Төслийн шугамаар ашиглагдаж байсан бол гаалийн татвар төлөлтийн талаарх мэдээлэл, холбогдох баримт;

2.3.4. Ашиглалтын явцад хийж гүйцэтгэсэн сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардал /шинээр тавьсан сэлбэгийн нэр төрөл, үнийн дүн/;

2.3.5. Ашиглалтад орсон он, балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл болон төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийг "Тээврийн хэрэгслийн маягт"-ын дагуу;

2.4. Машин тоног төхөөрөмжийн хувьд энэ журмын 2.1, 2.3-д зааснаас гадна дараах баримт, мэдээллийг ирүүлнэ.

2.4.1. Машин тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортын хуулбар;

2.4.2. Барилга байгууламжид суурилагдсан бол энэ тухай мэдээлэл;

2.4.3. Бусад шаардлагатай баримт материал.

2.5. Энэхүү журам дараах ажил үйлчилгээнд хамаарахгүй.

2.5.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн харилцааны зарим асуудлаар тусгайлан Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулсан тохиолдолд;

2.5.2. Орон нутгийн өмчийг хөтөлбөрийн хүрээнд хувьчлах арга хэмжээ;

2.5.3. Өмч хөрөнгийг худалдан авалтын хуулийн хүрээнд зохион байгуулж олж авсан;

### **Гурав. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ**

3.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон аймгийн ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авсан, үйлдвэрлэл, ажил үйлчилгээний үр дүнд бий болсон эсхүл иргэн, хуулийн этгээдээс үнэ төлбөргүй шилжүүлж авах, түүнчлэн хандив, тусламж, бэлэглэл, эрх залгамжлах журмаар олж авна.

3.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гарган хуульд заасан хугацаанд аймгийн Засаг даргад хүсэлтээ гаргана.

3.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эд хөрөнгө худалдан авах зөвшөөрөл олгох, үнийн дээд хязгаарыг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас баталсан төсөв болон, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан эх үүсвэрийг баримтлана.

3.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа чиг үүрэгт өөрчлөлт орсон, ажлын цар хүрээ нэмэгдсэн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан суудлын автомашин нэмж авах, цөөрүүлэх, зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл, тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах саналаа аймгийн Засаг даргад хүргүүлнэ. Аймгийн Засаг дарга саналыг аймгийн ИТХ-д тавьж шийдвэрлүүлнэ.

3.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээд автомашин шинээр худалдан авах санал ирүүлэхдээ өмнө ашиглаж байсан автомашиныг худалдах, шилжүүлэх, актлах асуудлыг хамтад нь тавьж шийдвэрлүүлнэ.

3.6. Аймгийн Засаг дарга энэхүү журмын 3.2, 3.4-т заасны дагуу эд хөрөнгө худалдан авахаар ирүүлсэн саналыг судлан шаардлагатай гэж үзсэн тохиолдолд саналыг нэгтгэн



аймгийн ИТХ-д хүргүүлж шийдвэрлүүлнэ.

## **Дөрөв. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОЛЖ АВСАН ЭД ХӨРӨНГИЙГ БҮРТГЭХ**

4.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт дахь хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан тухайн төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байгууллага нь бүртгэл хөтөлж тайлан тэнцэлдээ шууд бүртгэн авна.

4.2. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оруулж ажиллуулах ба барилга, байгууламжийг хүлээлцүүлсэн актыг үндэслэн бүртгэлд тусгах, үнэ өртгийг тооцон эзэмшигч байгууллагын санхүүгийн тайлан балансад бүртгэх ажлыг хамтран зохион байгуулна.

4.3. Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр, хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг тухайн иргэн, хуулийн этгээдээс албан ёсны зөвшөөрөл авсны үндсэн дээр үндсэн болон эргэлтийн хөрөнгөөр нь ангилан, ашиглах хугацаа, чанар байдлыг нь харгалзан, ашигласан хугацааны элэгдэл, хорогдлын шимтгэлийг тооцож данс бүртгэлдээ тусгаж байх асуудлыг хөрөнгө хүлээн авч буй хуулийн этгээд өөрөө хариуцана.

4.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч хүлээн авсан ажлын хэсгийн дүгнэлт, үнэлгээг үндэслэн шууд данс бүртгэлдээ тусгана.

4.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын хандивлагч байгууллага, иргэд, хуулийн этгээдээс хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй, маргаантай тохиолдолд Орон нутгийн өмчийн газарт асуудлаа тавьж зохих эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулна.

4.6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр орон нутгийн өмчлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг хүлээн авч, орон нутгийн өмчид бүртгэхдээ дараах материалыг бүрдүүлнэ.

4.6.1. Тухайн хөрөнгийг орон нутгийн өмчлөлд шилжүүлэх аймгийн ИТХ-ын шийдвэр, уг шийдвэрт шилжүүлэх хөрөнгийн зориулалт, хүчин чадал, үнэ өртөг, тоо хэмжээ, нэр төрөл, байршил, ашиглалт, чанар байдлыг тодорхой тусгасан байх;

4.6.2. Шилжүүлж буй үндсэн хөрөнгийн талаар эзэмшигч болон хүлээн авагч байгууллагуудаас тус тус санал, зөвшөөрлийг авах ба хүлээн авагч байгууллагад данс бүртгэлд тусгах талаар мэдэгдэнэ.

## **Тав. ЭД ХӨРӨНГИЙГ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ**

5.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал, эрхлэгч/ нь илүүдэлтэй буюу ашиглалтгүй эд хөрөнгийг шилжүүлэх тухай болон, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авах саналыг өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрөл авч, энэ журмын 2.1-д заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэн аймгийн Орон нутгийн өмчийн газарт ирүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.

5.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрт

зааснаар хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж, бүртгэл, тайланд хөдлөл өөрчлөлтийг хийнэ.

5.3. Үл хөдлөх болон их хэмжээний хөдлөх үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тохиолдолд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан хөрөнгө хүлээлцэх ажлыг зохион байгуулж болно.

5.4. Эд хөрөнгө шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг шилжүүлэн авсан байгууллага хариуцна.

### **Зургаа. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙГ ХУДАЛДАХ**

6.1. Орон нутгийн өмчит этгээдийн эзэмшилд байгаа илүүдэлтэй буюу ашиглалтгүй хугацаа дууссан, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг баримтлан гагцхүү дуудлагын худалдаагаар худалдана.

6.2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийн худалдах доод үнийг дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан мэргэжлийн /үнэлгээчний/ байгууллагын болон аймгийн Орон нутгийн өмчийн газрын оруулсан саналыг үндэслэн хэлэлцэн тогтооно.

6.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг дараах үзүүлэлтийг үндэслэн тогтооно.

6.3.1. Балансын болон үлдэгдэл өртөг;

6.3.2. Сүүлийн их засварын капиталжуулсан зардал;

6.3.3. Үл хөдлөх хөрөнгө оршин байгаа нутаг дэвсгэрийн газрын сангийн зэрэглэлийн нэгж талбайн суурь үнэлгээ;

6.3.4. Үл хөдлөх хөрөнгийн бодит үнэлгээ;

6.3.5. Мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

6.3.6. Зах зээлийн судалгаа, эрэлт, хэрэгцээ

6.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг дараах үзүүлэлтийг үндэслэн тогтооно.

6.4.1. Гарал үүсэл, зориулалт;

6.4.2. Ашигласан хугацаа;

6.4.3. Хөрөнгийн ерөнхий болон техникийн төлөв байдал /биет байдал/;

6.4.4. Балансын болон үлдэгдэл үнэ, ашиглалтын үеийн элэгдэл;

6.4.5. Ашиглах үеийн сүүлийн 3 жилийн сэргээн босголтын зардал;

6.4.6. Зах зээлийн судалгаа, эрэлт, хэрэгцээ.

6.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийг худалдах дуудлагын худалдааны журмыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас баталж мөрдөнө.

6.6. Үнэ тогтоон худалдан борлуулах, акталж, данснаас хасах шийдвэртэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгийг устгаснаас оруулах орлогын доод хэмжээг тогтоон өгч, тухайн өмч эзэмшигч байгууллагын удирдлага, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтан дор хэрэгжүүлнэ.

6.7. Орон нутгийн өмчит этгээдийн данс бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө, автомашины болон өөрөө явагч хэрэгслийг худалдах шийдвэрийг зөвхөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас гаргана.

6.8. Эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах шийдвэрт тухайн эд хөрөнгийг худалдах доод үнийг тогтоосон байна.

6.9. Орон нутгийн өмчит этгээдийн эд хөрөнгийг хувьчлах асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тусгайлан журамлаж шийдвэрлэнэ.

### **Долоо. ҮНДСЭН ХӨРӨНГИЙГ АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ**

7.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлтээр цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах саналаа энэ журамд заасан баримт материалын хамт аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж, эрх бүхий байгууллагын шийдвэр гарсны дараа хэрэгжүүлнэ.

7.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр данснаас хасна.

7.2.1. Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон;

7.2.2. Ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд;

7.2.3. Техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэн дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр солих шаардлагатай болсон эд хөрөнгө;

7.2.4. Балансын үнээ элэгдлээрээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөний улмаас гэмтэж эвдэрсэн, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон эд хөрөнгө;

7.2.5. Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь эрх бүхий байгууллагын тооцоогоор нотлогдсон эд хөрөнгө;

7.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээд эд хөрөнгө актлах саналаа аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхдээ энэхүү журмын 2.2-т заасан мэдээллээс гадна дор дурдсан зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна.

7.3.1. Данснаас хасах эд хөрөнгийн тодорхойлолт, хүсэлт;

7.3.2. Тоо хэмжээ;

7.3.3. Данснаас хасах болсон шалтгаан;

7.3.4. Уг эд хөрөнгийг акталж устгах, эсвэл акталж сэлбэгээр ашиглах тухай санал, хүсэлт;

7.3.5. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлт;

7.3.6. Байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай холбогдох мэргэжлийн байгууллагын акт дүгнэлт.

7.4. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс ирүүлсэн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах саналыг хянан үзэж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар болон бүрэн бүтэн байдал, харуул хамгаалалттын асуудлыг тухайн байгууллагын удирдлага хариуцах бөгөөд тус эд хөрөнгийн чанар, бүрэн бүтэн байдал алдагдвал зохих хууль

тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ.

7.5. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид нь үндсэн хөрөнгийг акталж данснаас хасахдаа дараах хэлбэрээр шийдвэрлэнэ.

7.5.1. Эд хөрөнгийг худалдах;

7.5.2. Иргэний хуулийн 105.1 дэх заалтын дагуу иргэнд давуу эрх олгож болно.

7.5.3. Цаашид ашиглахаар бусад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд шилжүүлэх;

7.5.4. Сэлбэг, материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах;

7.5.5. Шууд устгах;

7.5.6. Тухайн байгууллагын эзэмшилд буй газрыг цаашид ямар зориулалтаар ашиглах талаар эрх бүхий байгууллагын болон аймгийн Засаг даргын саналыг үндэслэх;

7.5.7. Газар дээрх болон газар доорх барилга байгууламжийг буулгах, ашиглаж болох материалыг үнэ тогтоон орлогод авах, хог хаягдлыг цэвэрлэх, газрыг нөхөн сэргээх.

7.6. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээрээ балансын үнээ нөхсөн, сэргээн засварлаж цаашид ашиглах боломжгүй болсон үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгийг актлах тухай саналаа Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлж аймгийн Орон нутгийн өмчийн газарт саналаа ирүүлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор шийдвэрлүүлнэ.

7.7. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй /хуучнаар/ бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн шинж чанарыг агуулсан хөрөнгийг данснаас хасахдаа энэ журмын 8.2, 8.3 дахь заалтыг баримтлан дарга, захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

### **Найм. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭД ХӨРӨНГӨ ОЛЖ АВАХ, БҮРТГЭХ, ШИЛЖҮҮЛЭХ, ХУДАЛДАХ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ**

8.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах тухай шийдвэрийг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор хэрэгжүүлнэ.

8.2. Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь үндсэн хөрөнгийг акталж сэлбэг материал, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах, данснаас хасах тухай шийдвэрийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийг устгалын акт, эргэлтийн хөрөнгөд орлого болгосон тэмдэглэл, худалдсан тухай акт хэлбэрээр баталгаажуулан, гүйцэтгэлийн үр дүнг холбогдох данс бүртгэлд тусгана.

8.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга /захирал, эрхлэгч/ нь энэ журмын 6.7-д заасан шийдвэрийг үндэслэн тушаал гарган, өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналтын дор хэрэгжүүлэн хөрөнгийн хөдлөлийг тайландаа тусгаж, энэ тухай аймгийн Орон нутгийн өмчийн газарт албан ёсоор хариу мэдэгдэж эд хөрөнгийн нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийлгэнэ.

8.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, худалдсан, акталж данснаас хассан эд хөрөнгийн хөдлөлийн нэгдсэн тайланг жил бүр эрх бүхий байгууллагаас баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн “үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн жилийн мэдээ” маягын



дагуу гаргаж аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлнэ.

### **Ес. ХАРИУЦЛАГА**

9.1. Энэ журмыг зөрчсөн буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай болон Зөрчлийн тухай хууль бусад хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллагын албан тушаалтанд хариуцлага хүлээлгэнэ.

9.2. Энэхүү журам болон эд хөрөнгө олж авах, худалдах, балансаас балансад шилжүүлэх, актлахтай холбогдсон бусад хууль тогтоомж, журмыг зөрчсөнөөс орон нутгийн өмчит хуулийн этгээдэд болон төсөвт учирсан хохирлыг буруутай этгээд хариуцна.

### **Арав. БУСАД**

10.1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хөрөнгийн элэгдлийн хугацаа, хэмжээг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баримтална.

10.2. Орон нутгийн өмчийн шилжүүлэх, худалдах, акталж данснаас хасах хөрөнгийн мэдээллийн маягыг аймгийн Орон нутгийн өмчийн газар батална.

10.3. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар, бүрэн бүтэн байдлыг тухайн байгууллагын удирдлага хариуцна.

10.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь эд хөрөнгийг харуул хамгаалалтаар хангах бөгөөд дутагдал, зөрчил гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.